



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/37/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 70584204 Цахим
хаяг: Tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Ж.Баяртуул
Утас: 70584207 Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	100
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	101
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	102
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	123
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	134
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.21 № 124

танай -ны № -т

ХЭРЛЭН СУМЫН 2 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Р.ЖАРГАЛТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520046



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Р.Жаргалтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 04-нөөс 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эх хэлээрээ зөв уншиж, ойлгож, өөрийгөө илэрхийлэх, чадвартай, зөв хандлагатай хүүхдийг төлөвшүүлэх”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 2 дугаар сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудлыг төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 496,013.3 мянган төгрөгөөс тооцон 9,920.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 14,335.3 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 204,233.2 мянган төгрөгөөр буюу 1.08 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, өглөг, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан элэгдэл, бараа материалын зэрэг данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	451,2	0	-451,2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	126,727.1	141,668.5	14,941.4
Үндсэн хөрөнгө	2,328,492.7	2,655,666.1	327,173.4
Элэгдлийн зардал	-29,772.6	-167,203.0	-137,430.4
Нийт хөрөнгө	2,425,898.4	2,630,131.6	204,233.2
Өр төлбөр	451.2	-	-451.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,425,447.2	2,630,131.6	204,684.4
Хуримтлагдсан үр дүн	553,947.9	758,632.3	204,684.4
Өмнөх үеийн үр дүн	553,947.9	553,947.9	-
Тайлангийн үеийн үр дүн		204,684.4	204,684.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	836,641.5	836,641.5	-
Төрийн өмчийн оролцоо	1,034,857.8	1,034,857.8	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,425,898.4	2,630,131.6	204,233.2

Бараа материалын дансны үлдэгдэл Боловсрол соёл, шинжлэх ухааны яамнаас хөрөнгө оруулалтаар 14,9 сая төгрөгийн сурагч ширээ болон ном сурах бичиг үнэ төлбөргүй хүлээн авч, 0,4 сая төгрөгийн хангамжийн материалыг акталсан зөрүү дүнгээр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яамны хөрөнгө оруулалтаар биеийн тамирын спорт заал 317,1 сая төгрөг, сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Гривцев”-ийн хөшөө 10,0 сая төгрөгийн нийт 327,1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна. Үндсэн хөрөнгийн элэгдэл өмнөх оноос өссөн нь 2018 онд хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэж хөрөнгийн үнэлгээ нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,630,131.6 мянган төгрөг болж өссөн нь тайлант жилд хийгдсэн хөрөнгө оруулалтаас шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ



хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хэрлэн сумын 2 дугаар сургууль нь тайлант онд үйл ажиллагааны орлого төлөвлөгдөөгүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 547,942.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд төлөвлөгдсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 541,443.9 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Тайлант жилд Боловсрол соёл урлагийн газраас хуваарилсан “Эко орчин бидний оролцоо” төслийн 200,0 мянган төгрөг, биеийн тамирын заал түрээсийн орлого 1305,0 мянган төгрөг, нийт 1505,0 мянган төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлсэн байна.

Үүнээс сумын засаг даргын захирамжаар урсгалт засварын зардалд 1305,0 мянган төгрөг, Эко-Орчин бидний оролцоо төсөлд 200,0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 31,645.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 6,823.3 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 166.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 24,656.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

1. Тайлант хугацаанд хийсэн 23,637.4 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”*, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч *Е баримтыг хавсаргах*” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв



2. Сургуулийн хүүхдийн хоолонд, материал бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээнд заагдаагүй 1,018.8 мянган төгрөгийн хүнсний материал авч зарцуулсан нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Тайлант жилд хүүхдийн хоолны зардлаас зориулалт бусаар 166,230.0 төгрөгийн хүнс худалдан авч зарцуулсан нь *Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын 2 дугаар сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хуулийн хугацаа болоогүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 50 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127 178 227,42	141 668 473,26
33	АВЛАГА	451 176,00	00,00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	451 176,00	00,00
35	БАРАА МАТЕРИАЛ	126 727 051,42	141 668 473,26
354	Хангамжийн материал	126 727 051,42	141 668 473,26
35410	Бичиг хэргийн материал	347 995,00	120 000,00
35420	Аж ахуйн материал	97 350,00	137 300,00
35470	Бусад хангамжийн материал	126 281 706,42	141 411 173,26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2 298 720 188,68	2 488 463 155,48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 298 720 188,68	2 488 463 155,48
392	Биет хөрөнгө	1 677 454 413,85	1 867 203 155,48
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 208 861 273,44	1 951 575 194,44
39202	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-152 945 888,60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63 694 398,90	63 304 398,90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-48 381 518,44	-54 549 663,52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55 797 206,50	55 536 419,40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23 608 690,48	-27 452 964,03
39214	Бусад үндсэн хөрөнгө	23 249 400,00	36 249 400,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5 588 344,07	-7 944 429,11
39216	Дуусаагүй барилга, байгууламж	400 000 000,00	00,00
39217	Ном	3 430 688,00	3 430 688,00
393	Биет бус хөрөнгө	621 265 774,83	621 260 000,00
39301	Програм хангамж	1 122 000,00	1 122 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1 116 225,17	-1 122 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	621 260 000,00	621 260 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2 425 898 416,10	2 630 131 628,74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	451 176,00	00,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	451 176,00	00,00
413	Өглөг	451 176,00	00,00
4136	Бусад өглөг	451 176,00	00,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	451 176,00	00,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2 425 447 240,10	2 630 131 628,74
51	Засгийн газрын хувь оролцоо	2 425 447 240,10	2 630 131 628,74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 034 857 771,64	1 034 857 771,64
51101	Өмч: - төрийн	1 034 857 771,64	1 034 857 771,64
512	Хуримтлагдсан үр дүн	553 947 958,42	759 211 234,16
51210	Өмнөх үеийн үр дүн	553 947 958,42	554 526 845,52
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	204 684 388,64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	836 641 510,04	836 062 622,94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	2 425 898 416,10	2 630 131 628,74



Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	520 199 620,00	921 245 304,34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51 468 920,00	371 662 704,34
120	Нийтлэг татварын бус орлого	18 095 900,00	371 662 704,34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18 095 900,00	371 512 704,34
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18 095 900,00	371 512 704,34
120009	Бусад орлого	00,00	150 000,00
121	Хөрөнгийн орлого	33 373 020,00	00,00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө	33 373 020,00	00,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26 337 500,00	35 340 600,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442 393 200,00	514 242 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26 337 500,00	1 640 600,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	17 625 000,00	00,00
131104	доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8 712 500,00	200 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон бусад орлого	00,00	1 440 600,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00,00	33 700 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	00,00	33 700 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	496 013 290,11	716 762 745,70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	496 013 290,11	716 762 745,70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	477 444 965,49	695 460 603,70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	313 900 502,00	409 885 700,00
210101	Үндсэн цалин	264 364 499,00	296 165 863,00
210102	Нэмэгдэл	30 540 317,00	72 693 148,00
210104	Урамшуулал	18 995 686,00	41 026 689,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38 132 083,53	51 235 700,00
210201	Тэтгэврийн даатгал	25 579 700,53	34 840 400,00
210202	Тэтгэмжийн даатгал	3 139 005,00	4 098 800,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 511 203,00	3 279 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	624 164,00	819 800,00
210205	Эрүүл мэндийн даатгал	6 278 011,00	8 197 700,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21 387 113,00	24 857 858,00
210301	Гэрэл, цахилгаан	6 348 550,00	7 482 134,00
210302	Түлш, халаалт	10 585 724,00	13 153 903,00
210303	Цэвэр, бохир ус	4 452 839,00	4 221 821,00
2104	Хангамж, бараа материалын зардал	15 875 926,23	7 868 757,55
210401	Бичиг хэрэг	5 323 304,00	2 026 439,00
210402	Тээвэр, шатахуун	3 000 000,00	1 886 700,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	286 000,00	671 000,00
210404	Ном, хэвлэл	2 944 200,00	00,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	207 400,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4 322 422,23	3 077 218,55
2105	Нормативт зардал	22 345 986,38	24 780 522,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	289 698,00	250 000,00
210502	Хоол, хүнс	21 697 488,38	23 289 330,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	358 800,00	1 241 192,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22 416 450,00	3 391 600,00
210604	Урсгал засвар	22 416 450,00	3 391 600,00
2107	Томилолт, зочны зардал	500 000,00	820 000,00
210702	Дотоод албан томилолт	500 000,00	820 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4 864 700,00	480 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	4 684 700,00	300 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэгдэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38 022 204,35	172 140 466,15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	435 100,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7 749 576,16	4 502 411,95
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29 772 628,19	167 202 954,20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18 568 324,62	21 302 142,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18 568 201,62	14 804 000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15 356 401,62	14 804 000,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс олгох тэтгэмж, урамшуулал	3 211 800,00	00,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,00	00,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,00	00,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	00,00	6 498 142,00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	6 498 142,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	24 186 329,89	204 482 558,64
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00,00	201 830,00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00,00	201 830,00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10 399 531,60	00,00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	10 399 531,60	00,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10 399 531,60	201 830,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13 786 798,29	204 684 388,64



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	468 730 700,00	549 582 600,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	468 730 700,00	549 582 600,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442 393 200,00	514 242 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26 337 500,00	1 640 600,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17 625 000,00	00,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8 712 500,00	200 000,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00,00	1 440 600,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00,00	33 700 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00,00	33 700 000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	468 730 700,00	549 582 600,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468 730 700,00	549 582 600,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450 213 377,00	528 280 458,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315 049 500,00	409 885 700,00
210101	Үндсэн цалин	264 811 346,00	296 165 863,00
210102	Нэмэгдэл	30 089 700,00	72 693 148,00
210104	Урамшуулал	20 148 454,00	41 026 689,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37 806 000,00	51 235 700,00
210201	Тэтгэврийн даатгал	25 204 004,00	34 840 400,00
210202	Тэтгэмжийн даатгал	3 122 374,00	4 098 800,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 548 719,00	3 279 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	629 955,00	819 800,00
210205	Эрүүл мэндийн даатгал	6 300 948,00	8 197 700,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21 662 113,00	25 201 858,00
210301	Гэрэл, цахилгаан	6 623 550,00	7 482 134,00
210302	Түлш, халаалт	10 585 724,00	13 153 903,00
210303	Цэвэр, бохир ус	4 452 839,00	4 565 821,00
2104	Хангамж, бараа материалын зардал	13 823 974,00	7 803 800,00
210401	Бичиг хэрэг	1 448 344,00	1 297 300,00
210402	Тээвэр, шатахуун	3 000 000,00	1 886 700,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	418 000,00	671 000,00
210404	Ном, хэвлэл	335 000,00	257 400,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	207 400,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8 622 630,00	3 484 000,00
2105	Нормативт зардал	23 655 490,00	24 900 500,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	270 000,00	250 000,00
210502	Хоол, хүнс	21 635 990,00	23 087 500,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 749 500,00	1 563 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19 386 500,00	3 440 600,00
210604	Урсгал засвар	19 386 500,00	3 440 600,00
2107	Томилолт, зочны зардал	500 000,00	820 000,00
210702	Дотоод албан томилолт	500 000,00	820 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13 217 300,00	480 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13 037 300,00	300 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5 112 500,00	4 512 300,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	435 100,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 612 500,00	4 077 200,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18 517 200,00	21 302 142,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18 517 200,00	14 804 000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15 305 400,00	14 804 000,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3 211 800,00	00,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00,00	6 498 142,00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	6 498 142,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00	00,00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00	00,00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 034 857 771,64	836 641 510,04	553 947 958,42	00,00	2 425 447 240,10
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 034 857 771,64	836 641 510,04	553 947 958,42	00,00	2 425 447 240,10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	578 887,10	00,00	578 887,10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 034 857 771,64	836 641 510,04	554 526 845,52	00,00	2 426 026 127,20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	-578 887,10	00,00	00,00	-578 887,10
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	204 684 388,64	00,00	204 684 388,64
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 034 857 771,64	836 062 622,94	759 211 234,16	00,00	2 630 131 628,74



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	547 942 000,00	541 443 858,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	547 942 000,00	541 443 858,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	533 138 000,00	526 639 858,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409 885 700,00	409 885 700,00
210101	Үндсэн цалин	295 512 300,00	296 165 863,00
210102	Нэмэгдэл	71 887 600,00	72 693 148,00
210104	Урамшуулал	42 485 800,00	41 026 689,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51 235 700,00	51 235 700,00
210201	Тэтгэврийн даатгал	34 840 400,00	34 840 400,00
210202	Тэтгэмжийн даатгал	4 098 800,00	4 098 800,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 279 000,00	3 279 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	819 800,00	819 800,00
210205	Эрүүл мэндийн даатгал	8 197 700,00	8 197 700,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31 700 000,00	25 201 858,00
210301	Гэрэл, цахилгаан	9 900 000,00	7 482 134,00
210302	Түлш, халаалт	15 200 000,00	13 153 903,00
210303	Цэвэр, бохир ус	6 600 000,00	4 565 821,00
2104	Хангамж, бараа материалын зардал	7 803 800,00	7 803 800,00
210401	Бичиг хэрэг	1 297 300,00	1 297 300,00
210402	Тээвэр, шатахуун	1 886 700,00	1 886 700,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	671 000,00	671 000,00
210404	Ном, хэвлэл	257 400,00	257 400,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу	207 400,00	207 400,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3 484 000,00	3 484 000,00
2105	Нормативт зардал	24 900 500,00	24 900 500,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	250 000,00	250 000,00
210502	Хоол, хүнс	23 087 500,00	23 087 500,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 563 000,00	1 563 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 000 000,00	2 000 000,00
210604	Урсгал засвар	2 000 000,00	2 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	820 000,00	820 000,00
210702	Дотоод албан томилолт	820 000,00	820 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	480 000,00	480 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	300 000,00	300 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4312300,00	4312300,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	435 100,00	435 100,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3 877 200,00	3 877 200,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14 804 000,00	14 804 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14 804 000,00	14 804 000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14 804 000,00	14 804 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	547 942 000,00	547 942 000,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	514 242 000,00	514 242 000,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	514 242 000,00	514 242 000,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33 700 000,00	33 700 000,00
132001	Орон нутгийн төсвөөс	33 700 000,00	33 700 000,00

